

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ТӨВ НОМЫН САН**



# **ШИНЭ НОМЫН МЭДЭЭ**

**№12**

**2013.04.15**

**Эмхтгэсэн: Ном зүйч М. Кунай**

**Ном зүйч Д. Алтанзул**

**Электрон каталоги:**

**<http://catalog.num.edu.mn>**

## ОДОН ОРОН, ГАЗАРЗҮЙ, ШУВУУ СУДЛАЛ



Мөнх-Очир Д. Сав, шим, хүн ертөнц хийгээд зурхай: Хоёр дахь хэвлэл /Хян. Ж. Баясах. – УБ.: 2012. – 118 х.

22.68

М-81 /БШУН унш-3ш/

Б-22481-22482

Одхүү Н. Газарзүйн тойм /Хян. М. Баянтөр. –УБ.: “Арангат Баянгол” хэвл. газар, 2013. -80х.


Зохиогч МУИС-д “Газарзүйн түүх” хичээл зааж байх үеийн хичээлийн төлөвлөгөөнд тулгуурлан энэхүү гарын авлагыг хэвлүүлжээ. Энэ номонд газарзүйн тоймыг эртний грек, ромын үеийн газарзүй, газарзүйн их нээлтийн үе, К.Риттер ба А.Гумбольдтын үндэслэсэн газарзүй, олон улсын газарзүйн холбоо, монголын нэрт газарзүйчид, Дорно дахины улсуудын болон монголчуудын газарзүйн мэдлэг гэсэн бүлгүүдэд хуваан авч үзжээ. Мөн 2004 оноос хойш монгол болон гадаад оронд газарзүйн ухаанаар докторын зэрэг хамгаалсан эрдэмтэдийн нэрсийг хавсралт болгон оруулжээ.



26.8г

О-20 /БШУН унш-3ш/

Б-22479-22480



Болдбаатар Ш. Монгол орны шувууны фото лавлах: 125 зүйл /Ред. О. Шагдарсүрэн. –УБ.: Улаанбаатар принт, 2008.

Энэхүү лавлах ном нь хүмүүсийн танин мэдэхүйд бага ч гэсэн хувь нэмэр оруулж өгөх байхаа. Монгол орныхоо нутгаар аялан, судалгаа явуулах замдаа авсан зургуудаас сонгон 125 зүйлийг багтаасан шувуу таних фото лавлах ном нь анхны бүтээл болно.


28.693.35/1/я6

Б-54

Б-22560

## КОМПЬЮТЕРИЙН ПРОГРАММ, ХИМИЙН НЭР ТОМЬЁО

Ундраа Д., Батзолбоо Б. **Өгөгдлийн сангийн системийн үндэс**: Анхны хэвлэл /Цс. Ганбат. – УБ.: Мөнхийн үсэг, 2013. – 257 х.



Уг номонд өгөгдлийн сангийн системийг загварчлах, хэрэгжүүлэх үндсэн зарчмуудыг танилцуулна. Үүнд өгөгдлийн шинжилгээ, загварчилгаа, шинжилгээ ба загварчлалын үе шатанд боловсруулагдан гарах загварууд, мөн өгөгдлийн санг удирдах системийн хэл, хэрэгсэл болон хэрэгжүүлэх арга техникийг чухалчлан жишээтэйгээр уншигчдадаа хүргэжээ. Энэ ном нь арван нэгэн бүлэг, тайлбарын хамт 140 гаруй зураг, диаграм, хүснэгттэй, монгол-англи нэр томъёоны жагсаалт болон жишээ өгөгдлийн санг боловсруулах СКЮЛ команд, Микрософт Аксесс хэрэгсэл дэх өгөгдлийн хүснэгт, талбаруудыг нэрлэсэн өгөгдлийн толийг агуулсан хоёр хавсралтаас бүрджээ.

32.973.26-018.2

У-36

/БШУН унш-7ш/

T-16206-16208



Мижиддорж Д. **Хими, химийн технологийн тайлбар толь** /Хян. М. Анхтуяа. – УБ.: Урлах Эрдэм, 2013. – 500 х.

Энэхүү толь нь дунд сургуулийн болон мэргэжил сургалтын төвийн сурагч, багш нар, дээд сургуулийн оюутан, хими технологи сонирхдог хэн бүхэнд төдийгүй уул уурхай, техник технологи, хөдөө аж ахуй, жижиг үйлдвэрт ажилладаг хүмүүс, тэрчлэн химийн нэр томъёог мэдэж байх шаардлагатай ажил эрхэлдэг ажилтан албан хаагчид, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудад ч бас хэрэг болж өгөх ажээ.

35я2

M-52

/БШУН унш-15ш/

B-22461-22465

## ЭМГЭГ СУДЛАЛ БА БОЛОВСРОЛЫН СОЦИОЛОГИ

Эрдэнэбаяр Л. Сэтгэц судлал. – УБ.: Сэлэнгэпресс, 2012. – 850 х.




Зохиогч номондоо сэтгэцийн тухай ерөнхий ойлголт, судлах зүйл, судалгааны аргууд, нийгмийн сэтгэцийн эмгэг судлал, эрүүл сэтгэцийн тухай ойлголт, сэтгэцийн тулгамдсан асуудал бий болох буюу хямралын тухай, сэтгэцийн эмгэг үүсэх эрсдэлт хүчин зүйлүүд, нийгмийн сэтгэцийн эмгэг үүсэх хүчин зүйлүүд, клиникийн сэтгэцийн эмгэг судлал, сэтгэцийн эмгэгийн шинж, хам шинжүүд, дотоод шалтгаант/удамшлын/ эмгэгүүд, гадаад шалтгаант/олдмол/ эмгэгүүд, эмгэгүүдийг эмчлэх ерөнхий зарчим, анагаахын сэтгэл судлал, эмгэг судлал, шүүхийн сэтгэцийн эмгэг судлал, донтох, хүүхдийн, өтлөлтийн, бэлгийн, сэтгэц нөлөөт эм судлал, сэтгэл засал, нөхөн сэргээлт, сэтгэцийн эрүүл мэндийн эрх зүйн аргууд, сэтгэл судлалын нэр томъёоны тайлбар зэргийг тус тус багтаан оруулжээ.

56.14

Э-73

/БШУН унш-2ш/

T-16216-16217



Ичинхорлоо Ш. Боловсролын социологийн удиртгал: Боловсрол судлалын магистр, докторын сургалтад зориулсан гарын авлага. – УБ.: Соёмбо принтинг, 2011. – 72 х.

Гарын авлагад боловсролын социологийн тухай, түүний зорилго, судлах зүйл, үндсэн асуудал, боловсрол, нийгэмшил, давхраажил, боловсролын социологийн судалгааны арга, боловсролын үзэгдэлд социологийн анализ хийх тухай бичжээ.

60.56

И-96

/НХШУН унш-7ш/

Б-22525-22527

## ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН

Баярмаа Ө. **Элжигэн халхчуудын ураг удмын хэлхээ** /Хян. Д.Мөнхочир. –УБ.: 2013. -32х.



Монголчуудын ураг төрлийг тодруулах санаачлагын эхлэл болгосон энэ бүтээлээс Элжигэн халхчуудын ураг удам болох Увс аймгийн Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан, Баруунтуруун сумынхан Зүүнханхөхий, Ханхөхий хошуунд амьдарч байсан өвөг дээдсээ 1922 оны хүн амын тооллогоос, дээр нь Зүүнхангай сумынхан 1933, 1944 оны хүн амын бүртгэлд тулгуурлан ураг төрлөө тодруулж чадах юм. Уг номын төгсгөлд жишээ болгон долоон үеэр нь оруулсан Ө.Даваабаярын “Ургийн бичиг”-т дурдагдаж буй өвөг дээдсийг нь 1922, 1933, 1944 оны тоологонд тулгуурлан гаргажээ.

63.3/1/

Б-38

/НХШУН унш-3ш/

Б-22445-22446



Болдбаатар Ж. **Монгол түмний сод хүмүүс**. Тэргүүн боть: Монголын төрийн зүтгэлтнүүд. /Хян. О.Амархүү. –УБ.: Соёмбопринтинг, 2013. -636х.

“Монгол түмний сод хүмүүс” хэмээх энэхүү ном нь 9 боть номноос бүрдэх бөгөөд энэхүү тэргүүн ботид Монгол төрийн үүсэл хөгжил болоод Монголын төрийн зүтгэлтнүүд болох Модун Шаньюй, Хамаг Монголын хаад, Г.Цэрэнчимэд, Т.Намнансүрэн, Ц.Дамдинбазар, А.Амар, П.Гэндэн, Ю.Цэдэнбал, Ж.Батмөнх, П.Очирбат, Ц.Элбэгдорж болон төрийн түшээ, хувьсгалыг оройлон манлайлагчид, мөн төр, цэргийн нэрт зүтгэлтэн зэрэг 42 хүний намтар, ажил үйлс, тэдний тухай ард олны дунд уламжлагдан яригдаж ирсэн домог, хууч яриа, болсон явдалын талаар өгүүлжээ.

63.3/1/8

Б-54

/НХШУН унш-3ш/

Т-16231-16232

Болдбаатар Ж. **Нэгэн жарны амьдрал**: Дэвтэр-И.П. ХХ зууны сүүлчийн хагасын монголын эгэл сэхээтний дүр төрх /Хян. Д. Дамба-Очир. – УБ.: Соёмбо принтинг, 2013.



Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, түүхийн ухааны доктор, профессор, академич Ж. Болдбаатарын энэхүү номыг хэн хүнгүй сонирхож болох дурдатгал, дурсамжын түүхэн сургамжтай үйл явдлуудыг өгүүлсэн хоёр дэвтрийг уншигч танд өргөн барьж байна.

63.3/1/-8

/НХШУН унш-3ш/

Б-54

Өнөр бүл-I. – 235 х.

T-16202-16203

Дурсамж, дурдатгал- II. – 346 х.

T-16204-16205



Лонжид З. **Түүх сөхөхүй.** –УБ.: Сэлэнгэпресс, 2011. -412х.

Энэхүү бүтээл нь түүхч эрдэмтэн З.Лонжидийн сүүлийн 20 гаруй жилийн туурвил юм. Энэ номонд Монголын улсын түүх болоод Богд хаан, Ханддорж, Дандаа, Дамдинбазар, Данзан, Бодоо, Сүхбаатар, Чагдаржав, Гэндэн, Намнансүрэн, Доржпалам нарын Монголын улс төрийн зүтгэлтэнүүдийн намтар, үйл ажиллагааны талаар өгүүлжээ. Зохиогчийн Монголын түүхийн судалгааны өгүүллүүдийн энэхүү түүвэр нь Монголын түүхийн судалгаа хийж буй эрдэмтэд, судлаачид болон суралцагч оюутан, сонирхон уншигч хэн бүхэнд түүхийн нэн чухал хэрэглэгдэхүүн болох ажээ.

63.3/1/

Л-75

T-16226

Лонжид З. **Цэргийн лам төрийн сайд Дарьзавын Лосол /1885-1940/.** –УБ.: 2013. -166х.

Ардын намын анхны долоогийн нэгэн, Ардын эрхт улсын Сангийн яамны анхны сайд, цэргийн лам, чойжин Дарьзавын Лосолын Монголын хувьсгалт төрд зүтгэсэн ээдрээт хувь заяа, зүтгэл, алдар гавьяаны талаар энэ номонд дэлгэрэнгүйгээр өгүүлжээ.



63.3/1/62

Л-75

Б-22503



Хоролдамба Д. **Түмэнд нэртэй түүхэнд мөртэй жанжин:** Судалгааны бүтээл /Ред. Д.Өлзийбаатар. –УБ.: Битпресс, 2012. -140х.

1930-1940-өөд оны их хэлмэгдүүлэлтийн үед Монгол ардын



хувьсгалт цэргийн олон шилдэг жанжин, дарга нар хэлмэгдэн, амь насаа алдсаны дотор Төв аймгийн Баянбараат сумын иргэн, Цэргийн явдлын яамны орлогч сайд, Бүх цэргийн жанжны орлогч корпус командлан захирагч /хурандаа генерал цолтой дүйцэх цол/ Цэрэнжавын Лувсандоной өртсөн ба Ц.Лувсандонойн гэм буруугүй хилс хэрэгт хэдмэгдсэнийг 1956 онд цагаатгажээ. Зохиогч энэ бүтээлдээ 1920-1930-аад оны Монгол орны дотоод гадаад байдалд дүн шинжилгээ хийж, Ц.Лувсандонойг төдийгүй тэр үеийн цэргийн дарга нарыг хэлмэгдүүлсэн учир шалтгааныг архивын баримтанд тулгуурлан гаргажээ.

63.3/1/62

X-48

Б-22502

Чулуунбаатар Л. **Ази, Африкийн орнуудын түүхийн дээж бичиг-1** /Хян. У.Гонгоржав. –УБ.: МУИС-ийн хэвлэх, 2013. - 137х.



Их, дээд сургуулийн оюутан, магистрант, докторант, ЕБС-ийн нийгмийн ухааны багш нарт зориулсан энэхүү дээж бичгийн эхний эмхэтгэлд их төлөв шийн үеийн Хятад, Энэтхэг, Япон болон Африк судлалын талаар тухайлан өгүүлжээ. Мөн түүнчлэн дэлхийд нэрд гарсан томоохон эрдэмтэдийн бүтээлээс гарын авлага болгож, гол асуудлыг хураангуйлан оруулжээ.

63.3/0/5

Ч-89

/НХШУН унш-15ш/

Б-22466-22470

## УГСААТАН СУДЛАЛ



Өлзийбаатар Д. **Хүрээ гоёл /1890-1920/:** Гэрэл зургийн цомог /Ред. З. Батнасан. – УБ.: Сэлэнгэпресс, 2013. – 237 х.

Энэхүү гэрэл зургийн цомогт Монголын шашин, төрийн зүтгэлтэн, бичиг, цэргийн түшмэд, эгэл хүмүүсийн Их Хүрээ/Нийслэл Хүрээ/-ний хувийн гэрэл зураг болоод гэртээ татуулсан гэрэл зургуудаас нь сонгон бүрдүүлжээ. Мөн цомогт тухайн үеийн хувцасны хэв маяг, донж, өмсгөл, зүүсгэлийн нэршил, торго

даавууны нэр, хийц онцлогуудын талаар уншигч танд тодорхой тайлбарлагдсан болно.

63.5/1/я6

Ө-74

T-16218-16220

## ЭДИЙН ЗАСАГ

**Монгол улсын санхүүгийн албаны түүх: I. 1911-1921 /Эмх.**  
З. Лонжид, Хян. Д. Махвал. – УБ.: 2006. – 119 х.



Энэхүү номын гол агуулга нь 1911 оноос 1921 оны долдугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд буюу Хаант Монгол улсын төрөөс тус орны санхүү, төсөв, эдийн засаг, аж ахуйн талаар баримталсан бодлого, түүний агуулга, хэрэгжилт, үр дүнг тодруулахад оршино. Мөн Хаант Орос улсаас Монголын Засгийн Газарт санхүүгийн зөвлөхөөр ажиллаж байсан С.А. Козик түүний туслах барон П.А. Витте нарын үйл ажиллагаа, орос генерал Р.Ш. Унгерний дарангуйллын үеийн монголын санхүү төсвийн талаар өгүүлэх аж.

65.02

M-69

B-22501



**Хэрэглэгчийн итгэлийн индекс.** Түүвэр судалгаа: Монгол, англи хэл дээр. –УБ.: 2013. -91х.

“Хэрэглэгчийн итгэлийн индекс”-ийг тооцох түүвэр судалгааг УБ хотод 2010,2011,2012 онд 3 удаа хийгээд байгаа ба “Хэрэглэгчийн итгэлийн индекс” нь эдийн засгийн ерөнхий байдал болон өөрсдийн санхүүгийн байдлын талаар хэрэглэгчид хэр зэрэг өөдрөг бодолтой байгааг хэмждэг ажээ. Уншигч та энэхүү судалгаанаас инфляци ба валютын ханшны талаарх хүлээлт, өрхийн зарлага, банкны секторт итгэх итгэл, ажилгүйдэл, ядуурал, орлого хуваарилалт, төрийн оролцоо, төрийн бодлогын талаарх өрхүүдийн үзэл бодлыг мэдэж авах болно.

65.9/1/-94

X-93

/НХШУН унш-3ш/

T-16134-16135



Энхмэнд Л. Санхүү, Татварын нэр томъёоны Англи-Монгол товч тайлбар толь /Хян. Д. Сувдаа. – УБ.: Соёмбо принтинг, 2013. – 288 х.



Толилуулж буй энэ товч тайлбар тольд санхүү, татвар, гаалийн түгээмэл хэрэглэгддэг 1700 орчим үг хэллэг, нэр томъёонуудыг орчуулж англи-монгол хэл дээр тайлбарлаж өгчээ. Тайлбар толь нь дэлхийн өндөр хөгжилтэй орнууд болох АНУ, Их Британи, Герман, Австрали, Канад зэрэг улсуудад хэрэглэгдэж буй татварын нэр төрөл, татвар хураах үйл явц, онцлогуудын талаарх нэр томъёонуудын тайлбар орчуулгыг багтаасан нь санхүү, татварын анхны ихээхэн ач холбогдолтой бүтээл болж чаджээ.

65.261я2

Э-66

/НХШУН унш-25ш/

T-16221-16225

## УЛС ТӨР СУДЛАЛ



Ганбат Ц. Онолгүй байна гэдэг өөрөө онол /Эмх. Л.Эрдэнэмаа. –УБ.: Мөнхийн үсэг, 2010. -293х.

“Үнэн” сонины ерөнхий эрхлэгч, доктор Ц.Ганбат өөрийн бичсэн, сонин сэтгүүлд нийтлүүлсэн, улс төрийн соёл буюу сэтгэлгээ, МАХН-ыг нозоорлоос сэргээх нийгмийн дуудлага, “Үнэн” сонин хэзээд оюуны хэрэгцээг хангах учиртай, ардчиллын үнэт зүйлсийг сонины хуудаснаа дархлагчид, орон нутгийн сонгуулийн сургамж, өлсгөлөн болон нийгмийн барометр, луйвар дээр зөвшилцдөггүй, сүүдрийн засгийн газар, МАХН шинэ имижийн эзэн байх болно, АН-ын элдэвлэлд мансуурах хэрэггүй, шинэ улс төрийн соёл түгээсэн нам зэрэг Монголын улс төр, нийгэм, “Үнэн” сонинтой холбогдолтой өгүүллүүдээ эмхтгэн “Үнэн” сонины 90 жилийн ойд зориулан ”Онолгүй байна гэдэг өөрөө онол” хэмээх ном болгон толилуулж байна.

66

Г-21

/НХШУН унш-3ш/

Б-22504-22505

**Жижиг улсын аюулгүй байдал:** Өнөө, ирээдүй /Эмх. Ж.Бор. –УБ.: 2010. -136х.



“Жижиг улсын аюулгүй байдал” хэмээх энэ номонд ХХI зууны босгон дээрх жижиг улсын аюулгүй байдлын зарим асуудлууд., жижиг улсууд тэдний аюулгүй байдлын асуудал., олон улсын аюулгүй байдал ба Монгол улс., мөнхийн хөршүүд ба аюулгүй байдлын бодлого, жижиг улсын аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар хангах нь хэмээх эрдэм шинжилгээ-судалгааны өгүүллүүд тус тус оржээ.

66.2

Ж-68

Б-22458-22460



**Түвшинтөгс А. Хүйтэн дайны дараах Монголын аюулгүй байдлын гадаад орчин:** Судалгааны бүтээлийн түүвэр. Монгол, англи хэл дээр. –УБ.: Мөнхийн үсэг, 2012. -675х.

Доктор, профессор, хурандаа А.Түвшинтөгсийн судалгааны бүтээлийн энэхүү түүвэр нь Монгол улсын үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын асуудлууд, хөрш орнуудын харилцаа, бүс нутгийн аюулгүй байдал, Зүүн хойд болон Төв Азийн аюулгүй байдал, Батлан хамгаалах асуудлууд гэсэн 6 бүлэгтэй ба энэ номонд Монгол улсын үндэсний аюулгүй байдал, түүний гадаад орчны талаар сүүлийн 20 жил бичиж хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүд оржээ. Тэрээр энэ номоо төрийн албан хаагчид, эрдэмтэн судлаачид, оюутан сонсогч нарт судалгааны гарын авлага болгон хэвлүүлжээ.

66.2/1/

Т-73

Т-16213-16215

## **ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ**

**Батдолгор Л. Монголын ба гадаад улсуудын тагнах үйл ажиллагаа** /Хян. Б.Энхмаа. –УБ.: Соёмбо принтинг, 2012. - 234х.



Хууль зүйн ухааны доктор, профессор, бэлтгэл хурандаа Л.Батдолгор Монголын шинэ үеийн тагнуулын алба үүсэн

байгуулагдсаны 90 жилийн ойд зориулан гаргасан энэ номонд монголчуудын тагнах үйл ажиллагааны түүхийг Хүннү гүрнээс 1990-д он хүртэлх хугацаанд хамруулан судалсан ба мөн түүнчлэн гадаадын зарим улсын тагнах үйл ажиллагааг дэлгэрэнгүйгээр авч үзжээ.

67.401.212

Б-33

Б-22483-22485



Бат-өлзий Д. **Уул уурхайн бизнесийн гэрээ: Эрх зүйн асуудал.** –УБ.: Соёмбо принтинг, 2013. -56х.

Энэхүү бүтээлд Монгол улс дахь эрдэс баялаг, уул уурхайн аж үйлдвэрийн эрчимтэй хөгжилтэй холбоотойгоор ашигт малтмалтай холбоотой бизнесийн харилцаа, түүний дотор хөрөнгө оруулалтын гэрээний харилцааны онцлог болон тэдгээрийн эрх зүйн зохицуулалтын талаар тусгасан ба энэхүү мэдлэгийг уул уурхайн бизнес эрхлэгчид, төрийн албан хаагчид, оюутан суралцагсдад түгээхийг зорьжээ. Түүнчлэн байгалийн баялагийн өмчлөл болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, концесс зэрэг эрх зүйн ойголт, институтын талаар онолын тайлбар хийж, мөн Оюутолгой ордын хөрөнгө оруулалтын гэрээ, түүний үр өгөөжийн тооцооллын тухай санаа бодлоо илэрхийлжээ.

67.407

Б-33

/НХШУН унш-3ш/


Б-22473-22474

Глазунов О. **Хятадын тагнуул** /Орч. С.Гомбо, М.Цогтоо. – УБ.: “Ном хур” ХК, 2012. -228х.

Уншигч та энэ номноос АНУ, Европ, Ази, Африк, Австрали, Ойрхи ба Алс Дорнодыг тагнуулч, туршуулын сүлжээгээрээ торлосон Хятадын тусгай албадын дэлхийг хамарсан нууц дайны тухай, тэдний тагнуулчид АНУ, ОХУ-аас орчин үеийн цэргийн зэвсэг техник, ШУТ-ийн шинэхэн ололтыг хэрхэн хулгайлж, өөрийн орныг дэлхийн тэргүүлэх гүрэн болоход нь тусалж байгаа тухай, Хятадын тагнуулч бүсгүй АНУ-ын ХМТ-ны зарим ажилтны толгойг хэрхэн эргүүлж байсан тухай гэх мэт сонирхолтой зүйлийг унших болно.



67.401.212/5Хят/



**Монгол улсын дээд шүүхийн тогтоолын эмхтгэл: 1959-2010** /Ред. А.Доржготов, Б.Ундрах. –УБ.: 2013. -1075х.

Монгол улсын шүүх байгуулагдсаны 101 жилийн ой, Улсын дээд шүүх байгуулагдсаны 85 жилийн ойг угтаж 1959 оноос 2010 он хүртэлх хугацаанд гарсан Монгол улсын шүүхийн тогтоолын тайлбарын эмхтгэлийг толилуулж байна. Энэхүү эмхтгэлд Монгол улсын дээд шүүхийн тогтоолуудыг он дарааллаар нь байрлуулжээ.

67.71/1/

М-69

Т-16228-16230

**Хүн худалдаалах гэмт хэрэг мөрдөх ажиллагааны арга зүй, тактик** /Орос хэл.орч. С.Батцэцэг. –УБ.: Ном хур, 2012. -216х. /Журавлев С.Ю., Крепышева С.К ба бус.



Энэ номонд орчин үед хилийн чанадад болон манай улсад ихээхэн газар аваад байгаа хүн худалдаалах гэмт хэрэг, түүнийг илрүүлж, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх арга зүй, тактикийн талаар жишээ баримт, судалгаанд тулгуурлан дэлгэрэнгүй өгүүлжээ. Энэхүү бүтээл нь цагдаа, тагнуул, шүүх, прокурорын болон холбогдох хууль зүйн байгууллагын ажилтан, оюутан, судлаачдад үнэтэй гарын авлага болох ажээ.

67.52

Х-82

/НХШУН унш-3ш/

Б-22471-22472



Эрдэнбат Д., Төрдалай Р., Алтантөгс Н. **Монгол улсын төрийн хяналт шалгалтын байгууллагын түүх** /Хян. Лонжид З., Батбаяр Б. –УБ.: Мөнхийн үсэг, 2012. -385х.

“Монгол улсын төрийн хяналт шалгалтын байгууллагын түүх”-ийг Санхүүгийн тогтолцоо бүрэлдэн тогтох үеийн төрийн хянан шалгах байгууллага /1922-1947/, БНМАУ-ын төрийн хянан шалгах байгууллагын хөгжил, төлөвшил /1947-1990/, Монгол улсын орчин цагийн хянан шалгах байгууллага /1990-2012/ гэсэн 3 бүлэгт хуваан авч үзсэн ба хөгжлийн түүхийг харуулахдаа Хянан шалгах байгууллагын

явуулсан үйл ажиллагааг голлон анхаарч, түүнд зохиогчдын зүгээс үнэлэлт дүгнэлт өгөхийн зэрэгцээ шалгалтын материал, акт, дүгнэлтүүдээс дэлгэрэнгүй иш татах замаар тухайн үеийн хяналт шалгалтын ажиллагааны тухай хөндлөнгийн тусгалгүйгээр уншиж танилцах боломжийг олгожээ.

67.401/1/

Э-73

T-16227

## **ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ, БОЛОВСРОЛ СУДЛАЛ**

**Эрдэм шинжилгээний бичиг: Сэтгүүл зүй №13/380/ МУИС, НШУС. – УБ.: МУИС-ийн хэвлэх, 2012. – 206 х.**



Монгол Улсад сэтгүүл зүй үүсч хөгжсөний 100 жилийн ойд зориулсан энэ удаагийн дугаартаа сэтгүүл зүйн онол, сэтгүүл зүйн түүх, сэтгүүл зүйн шүүмж, судалгааны талаарх бичсэн профессор, доктор, багш нарын өгүүллүүдийг уншигч олондоо толилуулж байна.

72

Э-73

/НХШУН унш-3, Лав-1ш/

T-16132-16133



**Ичинхорлоо Ш. Багшийн ном. –УБ.: Соёмбо принтинг, 2012. -168х.**

Энэхүү гарын авлагад багшийн тухай ухагдахуунд орчин үеийн байр сууринаас хандан багшийн мөрдөх зарчим, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа, ур чадвар, ёс зүй, хөдөлмөр зохион байгуулалт, анги удирдах ажил, багшийн хөгжил болон багшийн хөтлөх сургалтын бичиг баримт зэрэг хэрхэн өөрчлөгдөж буйг авч үзсэнээр багш болох оюутан, бүх шатны боловсролын байгууллагад ажиллаж буй багш нарт гарын авлага болох ажээ.

74.204я2


И-96

/НХШУН унш-10ш/

Б-22561-22565

**Ичинхорлоо Ш. Боловсролын тухай шинжлэх ухааны удиртгал. –УБ.: Соёмбо принтинг, 2012. -104х.**

Боловсролын чиглэлээр суралцдаг магистрант, докторантуудад зориулагдсан энэхүү гарын авлагад





боловсролын тухай шинжлэх ухаан үүсэн хөгжиж буй байдал, түүний бүтцэд хамаарах боловсролын философи, боловсролын социологи, боловсролын менежмент, боловсролын эдийн засаг, боловсролын эрх зүй, боловсролын түүх, боловсролын сэтгэл судлал, ерөнхий дидактик, харьцуулсан сурган хүмүүжүүлэх зүй зэргийн судлах зүйл, үндсэн асуудлын талаар өгүүлжээ.

74

И-96

/НХШУН унш-15ш/

Б-22531-22535



Ичинхорлоо Ш. **Боловсролын философи үзэл, санаа: Эрт ба эдүгээ** /Ред. Л.Жамц. –УБ.: Соёмбо принтинг, 2011. -76х.

Боловсролын философийн тухай, боловсролын хөгжлийн зарим зүй тогтол, эртний, дундад болон 20-р зууны үеийн боловсролын философийн хөгжлийн талаар өгүүлэх энэ номноос уншигч та боловсрол хүмүүжлийн талаар өөртөө хэрэгтэй, санаа оноонуудыг олж унших ажээ.

74.03

И-96

/НХШУН унш-10ш/

Б-22536-22540

Ичинхорлоо Ш. **Диссертацийн ажлын арга судлалын үндэс** /Ред. Ц. Цэвээн., О. Мягмар. – Соёмбо принтинг, 2011. – 94 х.

Энэ номонд диссертацийн ажил, түүнд тавигддаг үндсэн шаардлага, түүний бүтэц зэрэг нийтлэг шинжтэй зүйлийг дэлгэрэнгүй бичжээ.



74в7

И-96

/НХШУН унш-7ш/

Б-22528-22530



Ичинхорлоо Ш. **Дээд сургуулийн сургалт: Онол арга зүй** /Ред. Л.Жадамба. –УБ.: Соёмбо принтинг, 2012. -166х.

Их, дээд сургууль, коллежийн нийт багш нарт зориулагдсан энэ номонд дээд сургуулийн сургалтанд гарч буй өөрчлөлт, түүний суурь болсон дээд сургуулийн сургалтын технологи, сургалтын хөтөлбөр, гарын авлага, сургалтын арга зүй, багшийн хөгжил, судалгааны арга зүй, оюутны төлөвшил, сурах үйл ажиллагаа, лекц,



семинарын хичээл, оюутны бие даасан ажил, үнэлгээ, тестийн талаар авч үзжээ.

74.58

И-96 /НХШУН унш-15ш/

Б-22546-22550

Ичинхорлоо Ш. **Насанд хүрэгчдийн сургалтын гарын авлага:** Сурагч, багш, МСҮТ, мэргэжлийн сургуулийн багш нарт зориулав. – УБ.: 2013. – 160 х.



Гарын авлагад насанд хүрэгчдийн хөгжил, сургалтын бүтэц, зохион байгуулалт, сургалтын хөтөлбөр, арга зэргийн талаар болон орчин үеийн багш нар ямар байх, яаж хөгжих тухай өгүүлнэ.

74.4

И-96 /НХШУН унш-7ш/

Б-22554-22556



Ичинхорлоо Ш. **Орчин үеийн хичээлийн тухай өгүүлэх нь.** – УБ.: 2011. – 82 х.

Товхимолд хичээл гэж юу болох, түүнийг яаж сурагч төвтэй болгох талаар зохиогч зарим үзэл санаа, арга зам, хэрхэн хэрэгжүүлэх талаар бичжээ. Тухайлбал өнөөгийн хичээлд тавигдаж буй шаардлагын ангилал, төрөл зүйл, бүтэц, хичээлийн зорилтыг хэрхэн тайлбарлах, хичээлийн төлөвлөгөө хийх хувилбарууд, тэдгээрийн жишээ, хичээлийн технологийн тухай ойлголт, түүний хувилбарууд, жишээ нь, сурагч, шавь төвтэй хичээлийн технологи, сурагчдаар мэдлэг бүтээлгэх хичээлийн технологи, мөн хичээлд дүн шинжилгээ хийх хувилбар, хичээлээс гадуур зохиох ажлын талаар тус тус тодорхой өгүүлнэ.

74.26

И-96 /НХШУН унш-7ш/

Б-22519-22521

Ичинхорлоо Ш. **Судалгааны ажлын үндэс.** –УБ.: Соёмбо принтинг, 2013. -88х.



Энэхүү гарын авлагад судалгааны ажил гэдэг юу болох, боловсролын салбарт судалгааны ажлыг хэрхэн хийх 10 гаруй арга, судалгааны үр дүнг хийтийн хүртээл болгох 10 гаруй бүтээлийн талаар өгүүлэх ба боловсрол судлалын чиглэлээр судалгаа хийдэг магистрант, докторант, оюутнуудад гарын авлага болох ажээ.

74В7

И-96

/НХШУН унш-15ш/

Б-22541-22545



Ичинхорлоо Ш. **Сургалтын арга зүйн шинэчлэл** /Хян. Б.Жадамбаа. –УБ.: Соёмбо принтинг, 2011. -78х.

Дөрөв дэх удаагаа хэвлэгдэн, бүх шатны боловсролын байгууллагад ажиллаж байгаа багш нарт зориулагдсан энэ номонд сурган хүмүүжүүлэх 20 гаруй аргыг авч үзэн, тэдгээрийн дотоод агуулга, үр дүнтэй хэрэглэхийн тулд багшийн дагаж биелүүлэх шаардлага, хэрэглэх аргачлал зэргийг дэлгэрэнгүйгээр өгүүлжээ.

74.202.5

И-96

/НХШУН унш-7ш/

Б-22522--22524

Ичинхорлоо Ш. **Хамтран ажиллах ухаан.** – УБ.: Соёмбо принтинг, 2012. – 98 х.



1980-аад оны үед ид хүчээ авч байсан ЗХУ-ын /хуучнаар/ шинийг санаачлагч Новатор багш В.Ф. Шаталов, И.П. Волков, И.П. Иванов, С.Н. Лысенова зэрэг багш нарын тэргүүн туршлагыг монгол судлаачид орчуулан энэхүү эмхэтгэлд оруулжээ.

74.04

И-96

/НХШУН унш-7ш/

Б-22586-22588



Ичинхорлоо Ш. **Хүүхдийн хөгжил:** 4 дэх удаагийн хэвлэл. – УБ.: Ганзам пресс, 2013. – 154 х.

“Хүүхдийн хөгжил” хэмээх тус гарын авлагад хүүхэд гэж хэн болох, түүний хөгжлийн үндсэн агуулгыг дэлгэрэнгүй авч үзэхийн хамт сурахуй гэж юу болох, түүнд гарч буй өөрчлөлт, сурагч амжилтгүй суралцах шалтгаан зэргийг авч үзжээ. Энэ гарын авлагыг багш мэргэжлээр сурч байгаа бүх шатны сургуулийн оюутан, нийт багш нар, эцэг, эхчүүдэд зориулагдана.

74.200.

И-96

/НХШУН унш-7ш/

Б-22551-22553

Ичинхорлоо Ш. **Хүүхдээ хэрхэн хүмүүжүүлэх вэ?** Эцэг эхчүүдэд зориулсан ном /Хян. Л.Батдолгор. –УБ.: Соёмбо принтинг, 2012. -135х.



Эцэг эхчүүдэд хүүхдээ хэрхэн хүмүүжүүлэх талаар өгүүлэх энэ номонд хүмүүжил гэж юу болох, хүмүүжлийн зарим онцлог ба бүтэц агуулга, хүүхэд гэдэг хэн бэ? хүүхдийн эрх ба насны үечлэл, үе тус бүрийн онцлог, сургаж хүмүүжүүлэх ажлын агуулга, хүүхдийн хувийн онцлог, 12 орд тэдгээрийн агуулгын талаар дэлгэрэнгүй өгүүлжээ.

74.90

И-96

/НХШУН унш-7ш/

Б-22557-22559

### **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**



Отгонбаатар Б. **Аялал жуулчлалыг өргөжүүлэн хөгжүүлэх боломж** /Ред. Ц. Гүрбадам. – УБ.: Соёмбо принтинг, 2013. – 138 х.

Тус бүтээлдээ аялал жуулчлалын өнөөгийн бодит байдлыг задлан шинжилж, түүхэн харьцуулалт хийн, зохих санал дүгнэлтийг гарган, прогнозчилох үндсэн дээр хэтийн чиглэл, төлөвийг тодорхойлжээ.

75.81


О-53

/НХШУН унш-3ш/

Т-16209-16210

### **МОНГОЛЫН СЭТГҮҮЛ ЗҮЙ**

Баасансүрэн Т., Норовсүрэн Л., Уянга Б. **Монголын сэтгүүл зүйн шүүмж судлал: 5 боть цуврал.** –УБ.: 2013.



Монголын сэтгүүлчдийн эвлэл монголд тогтмол хэвлэл үүсэн буй болсны түүхт 100 жилийн ойд зориулж “Монголын сэтгүүл зүйн шүүмж судлал” хэмээх цуврал 5 ботийг хэвлэн гаргажээ. Сэтгүүл зүйн салбарт бүтээж туурвисан нь чамлалтгүй их, сэтгүүл зүйн судлаач, шүүмжлэгч, нийтлэлч болох Гэндэнжамцын Дэлэг., Тугалхүүгийн Баасансүрэн., Ломбын Норовсүрэн нарын намтар, уран

бүтээл, сэтгүүл зүйд оруулсан хувь нэмрийх нь тухай өгүүлэх цуврал номыг толилуулж байна.

76.01 /НХШУН унш-3ш/

Б-10

Сэтгүүл зүйн нэрт судлаач Г.Дэлэг. -94х. Б-22441-22442

Сэтгүүл зүйн нэрт судлаач, шүүмжлэгч Т.Баасансүрэн. -207х.  
Б-22439-22440

Сэтгүүл зүйн нэрт судлаач, нийтлэлч Л.Норовсүрэн. -164х.  
Б-22437-22438



Норовсүэрн Л., Зулькафиль М., Чойсамба Ч. **Монголын сэтгүүл зүй-100 жил: Хамгийн, хамгийн, хамгийн...** /Ред. Б.Галаарид. –УБ.: ВСІ, 2013. -231х.

Монголын сэтгүүл зүйн 100 жилийн хугацаан дахь хамгийн, хамгийн, хамгийн... хэмээх тодотголтой бүхнийг энэ номонд хамруулжээ. Үүнд монголын сэтгүүл зүйн түүхийг эхлүүлсэн хамгийн анхны сонин “Шинэ толь хэмээх бичиг”, монголын сэтгүүл зүйг үндэслэгч Ж.Цэвээн, тогтмол хэвлэлд анх нийтлэгдсэн хамгийн анхны зар, ухуулах хуудас, хувьсгалт нууц хэвлэл, нам төрийн албан ёсны хэвлэл “Уриа”, олон жил гарсан сонин “Үнэн”, гадаад оронд гаргасан хэвлэл, анхны радио нэвтрүүлэг, хошин шог сэтгүүл, ерөнхий сайд болсон сэтгүүлч, сэтгүүлчдийн анхны хурал, хөдөлмөрийн баатар болсон сэтгүүлч гэх зэрэг монголын сэтгүүл зүйн анхдагч болгоны тухай өгүүлжээ.

76.01

Н-74 /НХШУН унш-7ш/

Б-22449-22451

## ХЭЛ ШИНЖЛЭЛ

Дорж Ц. **Төвд хэл бичигт суралцах дэвтэр: Хоёр дахь хэвлэл** /Хян. Д. Дамба. – УБ.: Соёмбо принтинг, 2012. – 174 х.

Профессор Ц. Дорж багш нь төвд хэл бие даан суралцах хүмүүст зориулж гурван боть номныхоо эхний 1-р дэвтэр болох үгсийн аймгийг Төвд-Монгол бичгээс, Төвд-крилл бичигт буулган хэвлүүлжээ. Энэхүү сурах бичиг нь бие даан



суралцагчид болоод их, дээд сургуулиудын оюутан нарт гарын авлага болж өгнө.

81.2Төвд

Д-54

Т-16211-16212



Поппе Н. **Монгол бичгийн хэлний зүй** /Хян. Л. Чулуунбаатар. - УБ.: Удам соёл, 2012. – 289 х.

Н. Поппе нь зохиол бүтээлээ орос, англи, герман, франц, хятад хэлээр туурвидаг байсан бөгөөд гол гол бүтээл нь эдгээр хэл дээр орчуулагдажээ. Монгол хэл, уран зохиол, монголын судлалын талаар өгүүлсэн олон арван бүтээлээс “Алтайн хэл шинжлэлийн удиртгал”, ”Дурсамж” хэмээх хоёр номноос нь өөр ном монгол хэлэнд орчуулагдаагүй. Тиймээс энэ “Монгол бичгийн хэлний зүй” хэмээх номыг түүний мэндэлсний 115 жилийн ойд зориулан орчуулжээ.

81.2М-2

П-58

/НХШУН унш-7ш/

Б-22452-22454

Чулуунбаатар Л. **Орчуулга болон бас бус зүйлийн тухай өгүүллүүд**: Эрдэм шинжилгээний өгүүллүүдийн эмхэтгэл /Хян. Д. Отгонтуяа. – УБ.: Удам соёл, 2012. – 100 х.



Зохиогч энэхүү номондоо орчуулга гэж юу вэ, гадаад хэл сайн сурах нь орчуулагч болохын эхний алхам мөн, орчуулгын үндсэн салбар, өвөрмөц хэлцийн орчуулга, орчуулгын сургууль болон орчуулгын онолын сурах бичгийн тухай, азийн бөө нарын харанхуйн орны тухай ойлголт, латин үсэг ба түүний ази дахь хувь заяа, монгол үгийн энерги гэсэн өгүүллүүдийг багтаасан байна.


81.2-7

Ч-89

/НХШУН унш-7ш/

Б-22455-22457

## УРАН ЗОХИОЛ



Баллантайн Р.М. **Шүрэн Арал**: Номхон далайн тухай үлгэр /Анг. хэлн орч. М. Нарантуяа, Хян. Х. Батчулуун., П. Туяа. – УБ.: Жиком пресс, 2013. – 278 х.

Шотландын зохиолч Р.М. Баллантайн “ Шүрэн Арал” хэмээх адал явдалд зохиолоо 1958 онд бичжээ. Шүрэн арал хэрхэн бүтдэг далайн гүнд бидний төсөөлөхгүй ямар гайхалтай амьдрал, амьтан байдаг төдийгүй байгалийн сонин хачин үзэгдлийн тухай өгүүлнэ. Түүгээр ч үл барам талхан жимс, төмрөн мод, хаан самрын мод,

даавуун мод зэргээс фантастик дүрслэлийг ургуулж өгснөөрөө зохиолыг улам гайхашруулна. Номхон далайн арал дээр оршин суугч уугуул иргэдийн итгэмээргүй, нууцлаг амьдралтай танилцаж, тэдний соёл, хүний мах иддэг эсэх талаар мэдэх болно. Тиймээс эрхэм уншигч та өсвөр насны гурван хөвгүүн Жак, Ральф, Петеркин нартай Шүрэн Арлаар хамтдаа цуг аялаарай.

84/4Анг/-44

Б-22

/НХШУН унш-3ш/

Б-22447-22448

**Шагжийн Ванчаарай:** 1-6 боть. /Ред. Д. Цэнд., Д. Оюунбадрах. – УБ.: Мөнхийн үсэг, 2011.

Эдгээр зургаан боть номоо 80 насныхаа ойдоо зориулан бүтээжээ.

84/1/2-44

В-17



1-р боть: Өгүүллэгүүд. – 318 х.

Б-22489-22490

2-р боть: Яруугийн туужис. – 375 х.

Б-22491-22492

3-р боть: Хайр сэтгэлийн уянгын туужис. – 327

Б-22493-22494

4-р боть: Баримтат туужууд. – 251 х.

Б-22495-22496

5-р боть: Хүний мөс. – 396 х.

Б-22497-22498

6-р боть: Шагнал, шийтгэл. – 279 х.

Б-22499-22500



**Чулуунбаатар Л. Эрдэмийн өргөөний багана өргөгчид: Дээд дэвтэр.** – УБ.: Удам соёл, 2012. – 399 х.

Доктор, профессор Л. Чулуунбаатар багш МУИС-ийн 70 жилийн ойдоо зориулж өөрийн мэддэг багш, ажилтнуудынхаа тухай шүлэглэн бичсэн эхний дээд дэвтрээ хэвлүүлэн нийт уншигчдадаа өргөн барьжээ.

84/1/2-5

Ч-89

/НХШУН унш- 3ш/

Б-22477-22478

## ШАШИН СУДЛАЛ

**Мөнх-Очир Д. Зурхайн түүвэр толь: Дэвтэр-1.** – УБ.: “МСХ”, 2012. – 438 х.

Энэхүү дэвтэртээ зурхайн олон судар номноос нэгтгэн цэгцэлж ийнхүү нэртэйгээр хэвлүүлжээ.

86.2





**Монгол данжуур: Дандарын тайлбар:** Боть. 35-52 /Хян. Г. Диваасамбуу. – УБ.: Мөнхийн үсэг, 2012.


86.3

М-69	Боть:35. – 786 х.	Т-16136-16138
	Боть:36. – 546 х.	Т-16139-16141
	Боть:37. – 290 х.	Т-16142-16144
	Боть:38. – 376 х.	Т-16145-16147
	Боть:39. – 456 х.	Т-16148-16150
	Боть:40. – 362 х.	Т-16151-16153
	Боть:41. – 656 х.	Т-16154-16156
	Боть:42. – 600 х.	Т-16157-16159
	Боть:43. – 380 х.	Т-16160-16162
	Боть:44. – 452 х.	Т-16163-16165
	Боть:45. – 772 х.	Т-16166-16168
	Боть:46. – 652 х.	Т-16169-16171
	Боть:47. – 600 х.	Т-16172-16174
	Боть:48. – 692 х.	Т-16175-16177
	Боть:49. – 562 х.	Т-16178-16180
	Боть:50. – 918 х.	Т-16181-16183
	Боть:51. – 416 х.	Т-16184-16186
	Боть:52. – 266 х.	Т-16187-16189
	Боть:53. – 340 х.	Т-16190-16192
	Боть:54. – 394 х.	Т-16193-16195
	Боть:55. – 346 х.	Т-16196-16198
	Боть:56. – 272 х.	Т-16199-16201

### ГҮН УХААН

Рассел Б. **Философийн асуудлууд** /Орч. Н. Энхцогт., Ц. Алтантуяа, Хян. Б. Бадарч. – УБ.: Удам соёл, 2012. – 152 х.

Б. Рассел нь /1872-1971/, Английн философич, логикч, математикч, нийгмийн зүтгэлтэн байжээ. Английн неореализм ба неопозитивист чиглэлийг үндэслэгч юм. Математикийн шинжлэх ухааны үндэслэлийг бий болгох зорилгоор дедуктиваксиоматик байгууламжийг хөгжүүлжээ. Гол бүтээл нь математик логикийн суурь бүтээл болох “Математикийн үндэслэлүүд”, “Өрнийн гүн ухааны түүх” юм. Энх тайвны төлөө, дайны эсрэг



Пагуошийн хөдөлгөөнийг санаачлагчдын нэг. 1950 онд утга зохиолын салбарт Нобелийн шагнал хүртжээ. Тус эмхэтгэлд Б. Расселийн “Философийн асуудлууд” гэсэн гүн ухааных нь гол үзэл баримтлалыг илэрхийлсэн бүтээл болон “Фашизмын үүсэл”, “Шашны мөн чанар” гэдэг хоёр өгүүллийг нь орчуулан нийт уншигч олондоо түгээж байна.

87

P-24

/НХШУН унш-10ш/

Б-22581-22585



Томпсон Мел. **Шинжлэх ухааны философи**: Философигүй түүхийн анализ /Орч. Н. Энхцогт., Ц. Алтантуяа, Хян. Б. Бадарч. – УБ.: Удам соёл, 2012. – 230 х.

Нэрт эрдэмтэн Мел Томпсон энэхүү нэг сэдэвт бүтээлдээ шинжлэх ухааны сэтгэлгээ, шинжлэх ухаан ба философийн чухал үзэл баримтлалууд болон нийгмийн амьдралд шинжлэх ухааны зүгээс нөлөөлөх нөлөөлөлтэй холбоотой асуудлуудад нь гол анхаарлаа хандуулжээ.


87

T-48

/НХШУН унш-15ш/

Б-22576-22580

Рассел Б. **Өрнийн философийн түүх**: 1,2-р боть. Нэн эртнээс өнөөг хүртэлх улс төр, нийгмийн нөхцөлүүдтэй холбогдох нь /Орч. Н. Энхцогт., Ц. Алтантуяа, Ред. Д. Дашпүрэв. – УБ.: Удам соёл, 2012.



Английн нэрт математикч, сэтгэгч, нийгэм-улс төрийн зүтгэлтэн Б. Расселийн “Өрнийн философийн түүх” хэмээх энэ ном философийн мэргэжилтнүүдэд төдийгүй нийт уншигч, олон түмэнд гүн ухааны түүхийг хамгийн тодорхой оновчтой илэрхийлсэн бүтээл гэдгээрээ алдаршжээ. Б. Рассел нь ХХ зууны түүхэнд нэрээ үлдээсэн томоохон эрдэмтэн билээ.

87.3/0/

/НХШУН унш-15ш/

P-24

1-р боть: Эртний философи. – 412 х.

Б-22566-22570

2-р боть: Католик философи. – 277 х.

Б-22571-22575



**Муухай хятад хүн** /Орч эмх. Ж. Батболд, Ред. Б. Отгонсүрэн. – УБ.: Экимто, 2012. – 116 х.

Энэ номонд хятад хүний сэтгэл зүйн өвөрмөц онцлог, нийтлэг зуршил, эерэг сөрөг зан чанарууд, тэдэнтэй харилцахад анхаарах маш чухал асуудлуудыг сонирхол

татахуйц баримттай өгүүлэх ажээ.

87.774/5Хят/

М-90

/НХШУН унш-2ш/

Б-22475-22476

## ОРОС ХЭЛ ДЭЭРХ ЯПОНЫ УРАН ЗОХИОЛ

Адзути С. **Супермаркет**: Роман /Пер. с яп. А. Долина. – СПб.: Издательская Группа, Азбука-классика, 2009. – 480 с.



В романе знаменитого современного японского писателя Сатоси Адзути, популярного у себя на родине, однако на русском языке издаваемого впервые, на фоне перипетий вгораются нешуточные страсти в жизни ее сотрудников. Это роман о долге, чести и верности – семье, фирме, себе самому. Прочитав его и в очередной раз оказавшись в супермаркете, вы не просто механически наполните тележку продуктами, но с интересом и любопытством посмотрите...

84/5Яп/-44

А-29

М-3769



Коикэ М. **Без аккомпанемента** /Пер. с яп. А. Зинова. – СПб.: Гиперион, 2012. – 237 с.

Конец 60-х годов XX века. Япония охвачена студенческими волнениями. Посреди бушующего мира старшеклассница Кёко влюбляется в студента Ватару. Как бы сложились их судьбы, если бы не цепь роковых событий? Это повесть о том, что никто не может убежать от своего прошлого, а отголоски далекой юности звучат в нас всю оставшуюся жизнь.

84/5Яп/-44

К-59

С- 84718

Кэндзи Н. **Берег мертвых деревьев** /Пер. с яп. Ю. Окамото. – СПб.: Гиперион, 2012. – 312 с.



Автор этой книги родился и вырос в самое бураку, японских неприкасаемых, людей, которые до последнего времени не могли вступать в браки с обычными японцами, которые могли заниматься лишь черной работой. Этим людям были закрыты все пути к богатству, кроме незаконных, все пути к образованию, кроме самообразования, и все выходы из их переулков и

нищенских деревень, кроме, разве что, смерти. Но автор вовсе не настаивает на том, чтобы неприкасаемые были приняты в ряды одетых в костюмы служащих, у которых нет друзей, а есть сослуживцы, для которых не существует благородства, а есть только закон. Для автора описанная им семья и деревня, так похожая на его родину- последнее прибежище живой души в стране, которая потеряла свою душу...

84/5Яп/-44

К-98

Б-84716



Миябэ М. **Горящая колесница**: Роман /Пер.с яп. И.Мельниковой. – СПб.: Азбука, Азбука-Аттикус, 2012. – 416 с.


М.Миябэ – знаменитая писательница, за которой прочно закрепилась слава королевы современного японского детектива. Многие из четырех десятков книг, выпущенных Миябэ, награждены литературными премиями, среди которых престижнейшие Yamamoto Shugoro Prize и Naoki Prize. Детективные романы Миябэ переведены на все европейские языки, а в Англии ее называют не иначе как “японская Агата Кристи”. Один из самых знаменитых детективов – бестселлеров Миябэ, роман “Горящая колесница” впервые публикуется на русском языке. В 2008 году эта книга завоевала абсолютное первенство в читательском опросе, который проводился в Японии под девизом “Самая таинственная история”. В 2011 году по знаменитому роману Миябэ был снят телевизионный фильм.

84/5Яп/-44

М-71

Б-84717

Тавада Ё. **Подозрительные пассажиры твоих ночных поездов**: Повесть /Пер. с яп. А. Мещерякова. – СПб.: Издательская Группа Азбука-классика, 2010. – 192 с.



Настоящее издание является первой отдельной книжной публикацией писательницы в России. Главная героиня истории Ёко Тавада “Подозрительные пассажиры твоих ночных поездов” – молодая японская танцовщица, гастролирующая по Европе на поезде. Каждая глава этой изящной книги – новый город на пути героини, приключение, сон, мечта. С этого поезда невозможно сойти. Жизнь – долгое путешествие в вагоне на нижней полке... Путешествие в город, которого нет...

84/5Яп/-44

